



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/208

Номгон

Төлбөрийн баримт олголтыг эрчимжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 2 дугаар бүлгийн 2.1.1 дэх заалт, “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 12/55 тогтоолын хоёр дугаар хавсралтын 15 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нуугдмал орлогыг илрүүлж, татварт хамруулах, татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90 хүртэлх хувьд хүргэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллахыг Татварын хэлтэс (С.Рэнцэндагва), биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 5,000,000.00 (Таван сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

**АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН
АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
/Баянхонгор аймгийн Татварын хэлтэс/**

2023 оны 01 дүгээр сарын 10

Номгон

№	Үндсэн чиглэлийн зорилт	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	2023 онд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО					
2.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна.					
2.1.1	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90 хүртэлх хувьд хүргэх	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбогдсон, холбогдоогүй, иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн судалгаа мэдээллийг гаргах, үр дүнг тооцох	1 дүгээр сард	Байгууллагын төсвөөс	Татварын хэлтэс
		Улсын Их Хурлаас 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан журмыг иргэдэд сурталчлан, хэрэгжилтийг хангаж ажиллах /Бизнесийн үйл ажиллагааны чиглэл, салбар бүрд тохирсон танхимын болон цахим сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, гарын авлага хэвлүүлэх, Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгааны мэдээ мэдээлэл түгээх/	1-12 дугаар сард	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас 1.5 сая төгрөг, Байгууллагын төсвөөс	Татварын хэлтэс
		Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг томоохон зах худалдааны төвүүдэд төлбөрийн баримт олголтын хялбар шийдэл болох QR код бүхий наалтыг хэвлүүлж, байршуулах	1-12 дугаар сард	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас 2.0 сая төгрөг	Татварын хэлтэс

17/11

1	2	3	4	5	6
		<p>Ард иргэдээс ирсэн төлбөрийн баримт олгоогүй болон стандартын шаардлага хангасан QR код бүхий төлбөрийн баримт олгоогүй талаарх и-баримт аппликейшн болон Татварын албаны 1800-1288 тусгай дугаарын утас, аймгийн ЗДТГ-ын 7044-0001, Татварын хэлтсийн 70441288 дугаарын утсанд ирсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд цаг тухай бүр шийдвэрлэж, иргэдийн гомдлыг барагдуулах, зөрчил бүхий татвар төлөгчдөд хариуцлага тооцох</p> <p>Сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төлбөрийн баримт хэвлэх үүрэг бүхий татвар төлөгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалган туслах, зөрчил бүхий татвар төлөгчдөд хариуцлага тооцох</p>	Тухай бүр	Байгууллагын төсвөөс	Татварын хэлтэс
			1-12 дугаар сард	33	Татварын хэлтэс
		Иргэдийн зүгээс QR код бүхий наалтыг ашиглаж төлбөрийн баримтыг хэрхэн үүсгэх талаарх видео шторк бэлтгэж иргэдэд түгээх	5 дугаар сард	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас 500.0 мянган төгрөг	Татварын хэлтэс